

ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ, ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗӨВЛӨМЖ, ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

Харилцан холболтын болон сүлжээнд холбогдох зохицуулалт нь Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчимд тулгуурладаг бөгөөд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх зохицуулалтын нэг гол хүчин зүйл гэж үздэг.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5, 20.5.1-д радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдох, техник холболтын зааглах цэг, нөхцөлийг тогтооход Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4-д заасан буюу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 26 тоот тогтоолоор батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ыг (цаашид “Харилцан холболтын журам” гэх) баримтлана гэж заасан.

Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.18¹, 3.1.19²-д “харилцан холболт”, “сүлжээнд холбогдох” харилцааг тус тус тодорхойлсон бөгөөд радио, телевиз нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдож, хөтөлбөрөө дамжуулж буй харилцаа нь “сүлжээнд холбогдох” гэдэгт хамаарна.

Харилцан холболтын журмын хүрээнд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийг “харилцаа холбооны үйлчлэгч”, харин сүлжээнд холбогдож байгаа тал болох радио, телевизийг “харилцаа холбооны үйлчилгээгээр үйлчлэгч” гэж томъёолсон.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь Харилцан холболтын журмыг хэрэгжүүлэх, Сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (RAO³) боловсруулахад энэхүү зөвлөмжийг баримтална.

Энэхүү зөвлөмжийн хүрээнд байгуулах гэрээнд Харилцан холболтын журмаар зохицуулах зааглах цэг, холболт, дамжууллын талаарх техникийн харилцааг тусгах бөгөөд телевизийн бүтээл, контент, оюуны өмчийн харилцааг тусад нь авч үзэж, тусдаа гэрээ эсхүл нэмэлт гэрээ, хавсралтын хүрээнд зохицуулахыг зөвлөж байна. Мөн Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3-д заасан өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлстэй холбоотой харилцаа нь тус хорооноос баталсан “Үндсэн багцын зохицуулалтын журам”-ын хүрээнд зохицуулагдана.

¹ 3.1.18. “харилцан холболт” гэж хоёр үйлчлэгчийн сүлжээ хоорондын холболтыг;

² 3.1.19. “сүлжээнд холбогдох” гэж үйлчлэгч нь өөрийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх зорилгоор сүлжээ бүхий үйлчлэгчийн сүлжээнд холбогдохыг;

³ RAO - Reference Access Offer

НЭГ. ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Радио, телевиз нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдох гэрээ байгуулах процесс, түүнд хамаарах харилцан холболтын журмын заалтуудыг дараах хүснэгтээр харуулав.

№	Хамаарах тал	Журмын заалт
1	ОСДҮЭ	5.1.Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгийг Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.7, 22.3 заалтын дагуу Зохицуулах хороо энэхүү журмыг баримтлан Хавсралт 1-д заасны дагуу тодорхойлно.
2	ОСДҮЭ	2.5.Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (RAO) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж өөрийн веб хуудсанд байршуулах бөгөөд дараах мэдээллийг заавал тусгасан байна. Үүнд: 2.5.1.Тухайн сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага; 2.5.2.Зааглах цэгийн байршил; 2.5.3.Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл; 2.5.4.Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл; 2.5.5.Гэрээний загвар.
3	ТВ, Суваг	3.1.Харилцаа холбооны үйлчилгээгээр үйлчлэгч нь сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтийг харилцаа холбооны үйлчлэгчид бичгээр гаргана.
4	ОСДҮЭ	3.2.Харилцаа холбооны үйлчлэгч нь уг хүсэлтийг хүлээн авч өөрийн сүлжээний техникийн боломж, гэрээний нөхцөлийг хангаж буй эсэхийг нягталж, өөрийн сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх боломжтой эсэх талаар судалж, ажлын 10 хоногийн дотор хариуг хүсэлт гаргасан талд бичгээр мэдэгдэнэ. 3.3.Харилцаа холбооны үйлчлэгч нь техникийн нөхцөл гаргах боломжгүй бол хүсэлт гаргагч талд тухайн нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болох хугацааг тодорхой дурдсан холбогдох тайлбарыг хүргүүлэх ба хувийг Зохицуулах хороонд заавал ирүүлнэ.
5	ОСДҮЭ, ТВ, Суваг	8.3.2.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлд тусгах сүлжээнд холбогдох төлбөрийн тухай харилцан тохиролцсон эцсийн саналыг, тохиолцоогүй бол тус тусын саналыг үндэслэлийн хамт гэрээг шинээр болон шинэчлэн байгуулахаас ажлын 21 хоногийн өмнө Зохицуулах хороонд ирүүлнэ.
6	ХХЗХ	8.3.3.Зохицуулах хороо нь энэхүү журмын 8.3.1, 8.3.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг тооцооны үндэслэл болон тухайн салбарт төрөөс баримтлах бодлого, чиглэл, шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд хянаж, үндэслэлтэй гэж үзвэл зөвшөөрсөн тухай шийдвэрийг, хэрэв үндэслэлгүй гэж үзвэл ирүүлсэн саналаа дахин хянан үзэх тухай мэдэгдлийг, дүгнэлтийн хамт санал хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор сүлжээнд холбогдох, сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд оролцогч талуудад хүргүүлнэ.

7	ОСДҮЭ, ТВ, Суваг	8.3.4.Сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд оролцогч талууд нь Зохицуулах хорооны дахин хянаж үзэх тухай мэдэгдэл, дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шинэчилсэн саналаа үндэслэлийн хамт ирүүлнэ.
8	ХХЗХ	8.3.5.Энэхүү журмын 8.3.4-т заасны дагуу саналаа ирүүлээгүй эсвэл ирүүлсэн санал нь уг журмын 8.3.3-т заасан хүрээнд хянан үзэхэд хүлээн авах боломжгүй тохиолдолд Зохицуулах хороо нь сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд тусгах сүлжээнд холбогдох төлбөр, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр болон орлого хуваарилах зарчмыг шууд тогтоож, шийдвэрийг гэрээнд оролцогч харилцаа холбооны үйлчлэгч нарт хүргүүлнэ.
9	ОСДҮЭ, ТВ, Суваг	8.3.6.Энэхүү журмын 8.3.5-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээний төрөл болон онцлогоос үл хамааран гэрээнд тусган мөрдөх сүлжээнд холбогдох төлбөр, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр болон орлого хуваарилах зарчмыг Зохицуулах хорооны шийдвэрийн дагуу гэрээнд тусгаж, сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээг байгуулах үүрэгтэй.
10	ОСДҮЭ, ТВ, Суваг	9.3.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээг энэхүү журмын дагуу зөвхөн бичгээр, Монгол хэлээр байгуулна. 9.4.Сүлжээнд холбогдох гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор уг гэрээ болон түүний хавсралт, холбогдох баримт бичгийн хамт Зохицуулах хороонд бүртгүүлэх ба уг гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт бүрийг тухай бүр бүртгүүлнэ. 9.5.Зохицуулах хороо нь энэхүү журмын дагуу байгуулагдаагүй, сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний гэрээг бүртгэхээс татгалзах эрхтэй бөгөөд харилцаа холбооны үйлчлэгч нь уг гэрээг энэхүү журамд нийцүүлэн байгуулж, дахин бүртгүүлэхээр хандана. 9.6.Харилцаа холбооны үйлчлэгч нь гэрээг байгуулахаас өмнө Зохицуулах хороонд хандаж, гэрээний төслийг хянуулах болон холбогдох заавар зөвлөмжийг авч болно.

ХОЁР. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ (RAO) БОЛОВСРУУЛАХ

Харилцан холболтын журмын 2.5-д заасны дагуу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь өөрийн сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж, өөрийн вэб хуудсанд байршуулах үүрэгтэй.

Энэхүү зөвлөмжийн хүрээнд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдох гэрээний нөхцөл (RAO)-ийн үлгэрчилсэн загварыг боловсруулсан ба тухай бүрд тайлбар, зөвлөмжийг (дөрвөлжин хаалтад цэнхэр өнгөөр) оруулж өгөв.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь энэхүү зөвлөмжийн дагуу сүлжээнд холбогдох нөхцөлийг боловсруулах нь Зохицуулах хорооноос түүнийг хянах, холболт, дамжууллын гэрээ бүртгэх процессийг хялбар болгох, бүх талууд нэгдсэн ойлголттой байхад тустай юм.

..... **КОМПАНИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ /RAO/
[боловсруулах загвар, зөвлөмж]**

Энэхүү баримт бичгээр Телевизийн үйлчилгээ эрхлэгчтэй байгуулах холболт, дамжууллын гэрээний нөхцөлийг тодорхойлсон ба Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2017 оны 16 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2.5 дах хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

..... компани нь олон суваг дамжуулах үйлчилгээг тоот тусгай зөвшөөрөлтэйгээр [хамрах хүрээ] –нд хүргэдэг. гм.

[Энд компанийн үзүүлдэг олон суваг дамжуулах үйлчилгээний Аж ахуйн нэгжийн нэр, тусгай зөвшөөрлийн дугаар, хамрах хүрээ, үйлчилгээ болон үйлчилгээний онцлогийн талаар товч мэдээллийг оруулах]

1. Сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага

Телевизийн студиас өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт (PAL)	[SD форматаар дамжуулах бол SMPTE 259M-C (SD-SDI), ITU-R BT601 стандартыг хангасан байх.]
	[HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI), ITU-R BT709 стандартыг хангасан байх.]
Дууны оролт	[Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)]
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дэлгэцийн харьцаа	[4:3, 16:9]
SD нягтрал /пикселийн тоо/	[SD-SDI 625@50i гэх мэт]
HD нягтрал /пикселийн тоо/	[HD-SDI, 1080@50i, шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264) гэх мэт]
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	[Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу дууны гаралтын түвшин -18dBFS, эгшин зуурын утга нь ± 1 байна.]
Дууны кодлол	[Стерео болон MPEG layer 1, 2, 3 , AAC, AES гэх мэт]

2. Зааглах цэгийн байршил, ашиглалт үйлчилгээ

[Харилцаа холбооны тухай хуулийн “22.2. Үйлчлэгч нь техникийн боломжийг харгалзан өөрийн сүлжээнд бусад сүлжээг саадгүй холбох нөхцөлийг хангана.” гэж заасныг анхаарах]

2.1. Сүлжээнд холбогдох зааглах цэгийн боломжит байршлуудыг дараах хүснэгтэд харуулав.

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)	Тайлбар, нэмэлт мэдээлэл
Байршил 1:	
Байршил 2:	
Байршил 3:	

[Харилцан холболтын журмын 2.6-д заасны дагуу ОСДҮЭ нь зааглах цэг дээр ялгаваргүй, ижил тэгш нөхцөл бүрдүүлэх хүрээнд холболтын боломж, нөөцийн мэдээллийг ХХЗХ болон үйлчилгээ эрхлэгчдэд нээлттэй мэдээлнэ.

Харилцан холболтын журмын 5.2-д заасны дагуу зааглах цэгийн байршлыг ОСДҮЭ тодорхойлж байгаа тохиолдолд уг цэгийг ОСДҮЭ-ийн сүлжээний нэг хэсэг гэж үзэх бөгөөд ашиглалт үйлчилгээг ОСДҮЭ бүрэн хариуцна.]

2.2 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн студиас зааглах цэг хүртэлх сүлжээг (сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэрэг) хариуцна.

[Харилцан холболтын журмын 5.4-д заасны дагуу Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох холболтын зааглах цэгээр тусгаарлан холбогдох хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийн бүрдүүлж, хангана.

Харилцан холболтын журмын 7.2-д заасны дагуу талууд сүлжээнд холбогдох зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцна.]

2.3. Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь зааглах цэгийг дээр зааснаас өөр цэгт тогтоох саналтай бол хүсэлтийг албан бичигтээ тодорхой дурдаж, техникийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг ирүүлнэ. Хэрвээ тус зааглах цэг нь Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын Хавсралт 4-д зааснаас өөр газарт байрлах бол албан бичгийн хувийг Зохицуулах хороонд илгээж, шийдвэрлүүлнэ.

2.4 Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

[ОСДҮ-ний сүлжээнд холбогдоход нэмэлтээр тоног төхөөрөмж шаардлагатай эсэх, хэрвээ шаардлагатай бол уг тоног төхөөрөмжийн зориулалт, ямар учраас шаардагдаж байгаа тухай, тус төхөөрөмжийн төрөл маркийн мэдээлэл, түүнийг аль талаас гаргах, өмчлөл зэргийг тодорхой дурдана.]

2.5 Холболтын схем, зураглал

[Телевиз талын дамжуулах төхөөрөмж, холболтын зааглах цэг, ОСДҮЭ-ийн хүлээн авах төхөөрөмж зэрэг шаардлагатай төхөөрөмжийг оролцуулж, холбогдох мэдээллийг тэмдэглэсэн схем зураг оруулах]

3. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсэн мэдээлэл

[Гэрээ хийх процесс, ямар асуудлаар хэнтэй харилцах тухай заах]

4. Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл

[ОСДҮЭ нь Телевизийг холбож, дамжуулахад төлбөр авдаг бол төлбөрийн үндэслэл, задаргааг ойлгомжтой, тодорхой тайлбарласан байна. Мөн ямар тохиолдолд төлбөр авахгүй тухай тайлбарлана.]

[Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын 2.9-д заасны дагуу Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээ байгуулах, төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй, мөн журмын 8-р хэсгийг баримтална.]

	Төлбөрийн задаргаа	Үндэслэл, тайлбар	Төлбөрийн хэмжээ	Төлөх хугацаа, давтамж
1				
2				
3				
4				

5. Гэрээний загвар

[Гэрээнд тусгавал зохих зүйл, заалтуудыг багтааж, гэрээний загварыг боловсруулан доор зөвлөмж болгов.]

_____, БОЛОН _____-ИЙН ХОЛБОЛТ, ДАМЖУУЛЛЫН ГЭРЭЭ

20____.____.____

№

Улаанбаатар хот

[1.1. Гэрээ байгуулах хууль, эрх зүйн үндэслэл]

Холболт, дамжууллын энэхүү гэрээ нь Дэлхийн Худалдааны Байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Харилцаа холбооны тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай болон бусад холбогдох хуулиуд, ХХЗХ-ноос батлагдан гарсан харилцан холболт, холболтын талаархи холбогдох журмууд болон тус тусын байгууллагын дүрэмд үндэслэсэн болно.

[1.2 Гэрээ байгуулж буй талуудын нэр, хаяг, төлөөлж буй албан тушаалтан]

Нэг талаас: _____/цаашид “**Дамжуулагч тал**” гэх/, түүнийг төлөөлж _____,

Нөгөө талаас: _____/цаашид “**Телевиз**” гэх/, түүнийг төлөөлж _____, нар /хамтад нь “Талууд”, зарим тохиолдолд дангаар нь “Тал” гэх/ доорхи нөхцөлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

Нэг. Ерөнхий зүйл

Хоёр. Техникийн нөхцөл

Гурав. Ашиглалт үйлчилгээ

Дөрөв. Төлбөр тооцоо

Тав. Харилцан мэдээлэл солилцох

Зургаа. Хариуцлага

Долоо. Маргаан шийдвэрлэх

Хавсралт 1. Холболт хийх техникийн үзүүлэлт

Хавсралт 2. Зааглах цэгийн байршил, зураглал

Хавсралт 3. Харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан

Хавсралт 4. Төлбөрийн мэдээлэл

Хавсралт 5. Телевизийн хөтөлбөр ирүүлэх формат

Нэг. Ерөнхий зүйл

[1.3 Холболтын зорилго, төрөл, хамрах хүрээ]

1.4 Холболтоор дамжин хийгдэх үйлчилгээний нэр, төрөл]

1.1. Нэг талаас Дамжуулагч нь [Кабелиар, АйПиТВ-ээр, Хиймэл дагуулаар, Утасгүй сүлжээний /DTV/ гм технологийн төрлөө сонгож заах] олон суваг дамжуулах өөрийн сүлжээнд Телевизийн сувгийг холбож дамжуулах, нөгөө талаас Телевиз нь өөрийн хөтөлбөрийг Дамжуулагчийн сүлжээний _____ [Хамрах хүрээ: Улаанбаатар, орон нутагт хаана гэдгийг тодорхой заах, шаардлагатай бол аймгийн жагсаалтыг гэрээнд хавсаргах] хэрэглэгчдэд хүргэх зорилгоор Телевиз нь Дамжуулагчийн сүлжээнд холболт хийх болон хөтөлбөрийг дамжуулах хэлцлийн нөхцөл, түүнтэй холбоотой асуудлыг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

[Гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа]

1.2. Талуудын эрх бүхий төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан /тамга дарах/ өдрөөс эхлэн ___ жилийн хугацаанд хүчин төгөлдөр болно. (ЭСВЭЛ Талуудын эрх бүхий төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан /тамга дарах/ өдрөөс эхлэн талуудын тусгай зөвшөөрлийн аль түрүүлж дуусах хугацаагаар буюу ___ оны ___ сарын ___ хүртэл хүчин төгөлдөр байна. Энэ тохиолдолд талууд тусгай зөвшөөрлийн хуулбарыг гэрээнд хавсаргана.)

1.3. Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-д заасны дагуу 10 хоногийн дотор талууд хавсралтуудын хамт гэрээг ХХЗХ-д хүргүүлж, бүртгүүлнэ.

1.4. Талууд холболт, дамжуулал хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.

[1.6 Талуудын эрх үүрэг]

1.5. Талууд холболт, дамжууллын гэрээнд дор дурдсан эрхийг эдэлнэ. Үүнд:

1.5.1. талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаасаа шаардах;

1.5.2. гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;

- 1.5.3. өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах;
 - 1.5.4. энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд энэ гэрээний 6 дугаар зүйлд заасан хариуцлагын механизмыг шат дараатайгаар хэрэглэх.
- 1.6. Талууд холболт, дамжууллын гэрээнд дор дурдсан үүргийг хүлээнэ.Үүнд:
- 1.6.1. гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
 - 1.6.2. үйлчилгээний чанар, техникийн стандарт, нөхцөл шаардлагыг хангах;
 - 1.6.3. гэрээнд заасны дагуу төлбөр төлөх;
 - 1.6.4. гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх;
 - 1.6.5. өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө тал болон гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх;
 - 1.6.6. гэрээнээс үүдэлтэй маргаантай асуудлыг зөвшилцлийн журмаар шийдвэрлэх
 - 1.6.7. гэрээний үүргээ биелүүлээгүй шалтгааны улмаас холболтыг салгах, хязгаарлалт хийх бол нөгөө тал болон Зохицуулах хороонд 72 цагийн өмнө үндэслэлийн хамт, дамжуулагч талын сүлжээний хэрэглэгчдэд 42 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;

[1.7 Гэрээг сунгах, өөрчлөх, цуцлах үндэслэл]

1.7. Гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг дахин нэг жилийн хугацаатай сунгагдсанд тооцно. (ЭСВЭЛ Гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах санал гаргаагүй, тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан талын тусгай зөвшөөрөл нь сунгагдсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбарыг гэрээнд хавсаргаж, тусгай зөвшөөрлийн аль түрүүлж дуусах хугацаагаар гэрээг сунгагдсанд тооцно.)

1.8. Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дараагийн гэрээ батлагдсан өдрөөр дуусгавар болно. [Тусгай зөвшөөрлийн хугацаагаар энэ гэрээг байгуулаагүй тохиолдолд энэ заалтыг ашиглах]

1.9. Өмнөх гэрээний нөхцөл, заалтууд нь дараагийн гэрээ байгуулагдах хүртэл харилцааг зохицуулна. [Өмнөх гэрээний хугацаа дуусч, дараагийн гэрээ байгуулагдах хүртэл зарим тохиолдолд завсар үүсч, тодорхойгүй байдал бий болох үед хэрэгтэй гэж гэж үзсэн. Хууль зүйн үүднээс боломжтой эсэхийг нягтлах]

1.10. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор Талуудын хоорондоныдугаар сарын-ний өдөр байгуулсан “.....” холболт, дамжууллын гэрээг цуцлагдсанд тооцох ба дээрх гэрээг цуцалсан нь уг гэрээний төлбөрийн шаардлага гаргах эрхийг хөндөхгүй буюу дуусгавар болгохгүй, тухайн шинэ гэрээ байгуулах хүртэлх хугацааны төлбөрийг тооцон бүрэн төлж барагдуулна. [1.9 дэх нөхцөл байдалтай адил]

1.11. Энэхүү гэрээнд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.

1.12. Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг Харилцаа холбооны зохицуулах хороонд тухай бүр хүргүүлж, бүртгүүлж байна.

1.13. Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээг цуцалж болно. Талуудын аль нэг нь энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг хүсвэл энэ тухайгаа нөгөө Талдаа ... –с доошгүй хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэх ба нөгөө Тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.

1.14. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх, эсхүл удаа дараа биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх тухай албан бичгийг хүргүүлнэ. Албан бичиг хүргүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа тохиолдолд нөгөө тал нь энэхүү гэрээний 6.3-д заасны дагуу дараагийн үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэх эрхтэй.

1.15. Энэхүү гэрээний 1.14-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэж эхэлснээс хойш 14 хоногийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал нэг талын санаачлагаар гэрээ цуцлах тухай албан тоотыг нөгөө талдаа хүргүүлнэ.

1.16. Телевиз нь Дамжуулагчийн _____/үйлчилгээний багцын нэр/ багцын _____ дугаар сувагт байрлах ба дараах нөхцөлд Дамжуулагч сувгийн дугаарт өөрчлөлт оруулж болно. Үүнд:

А. Дамжуулагчийн сүлжээгээр дамжиж байгаа бусад сувгууд хасагдах, нэмэгдэх

Б. Дамжуулагч өөрийн үйлчилгээний багцад шинэчлэлт, өөрчлөлт оруулах

В.

1.17. Энэхүү гэрээний 1.16-д заасны дагуу Дамжуулагч сувгийн дугаарт өөрчлөлт оруулах бол Телевизэд _14_ хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

[Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26.4.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь хууль болон гэрээнд зааснаас бусад үндэслэлээр дамжуулж байгаа хөтөлбөр, сувгийн дараалалд өөрчлөлт оруулах, хэсэгчлэн болон бүрэн хаахыг хориглоно. Гэж заасан.]

1.18. Талууд дор дурьдсан тохиолдлоос бусад ямар ч тохиолдолд холболтыг салгах, хязгаарлалт хийхгүй байна. Үүнд:

А. Давагдашгүй хүчин зүйлс;

Б. Гэрээнд оролцогч тал цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон болон дампуурсанаа албан ёсоор зарласан;

В. Гэрээнд оролцогч тал харилцан холболтын төлбөрөө төлөөгүй гэрээнд тохиролцсон боломжит хугацаанаас _3_ сараар хэтрүүлсэн;

Г. Техникийн гэмтэл саатал гарсан, эсвэл засвар, үзлэг шалгалт хийхээр харилцан тохиролцсон;

Д. Эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэл бүхий мэдэгдэл ирүүлсэн.

Хоёр. Техникийн нөхцөл, зааглах цэг

2.1. Холболт хийх техникийн нөхцөл:

- 2.1.1. Холболт хийхэд шаардагдах техник төхөөрөмж, түүнд тавигдах шаардлага, стандарт үзүүлэлт зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байна. Хавсралт 1-д орсон өөрчлөлтийг тухай бүр тусгаж байна.
- 2.1.2. Телевизийн студиас ирэх дохио нь Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хангасан байна.
- 2.1.3. Талуудын сүлжээ хооронд холболт хийх дамжуулах шугам нь __ (өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ) __ байна.

2.2. Зааглах цэг:

- 2.2.1. Зааглах цэг нь Дамжуулагч талын сүлжээний нэг хэсэг бөгөөд зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна.
- 2.2.2. Сүлжээний зааглах цэгийн байршил, холболтын зураглал нь Хавсралт 2-т заасны дагуу байна.
- 2.2.3. Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.

Гурав. Ашиглалт үйлчилгээ

3.1. Зааглах цэгээс 2 тийш Талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ буюу бүрэн бүтэн байдал, тасалдалгүй найдвартай ажиллагаа, чанарын хяналт, гэмтэл засварыг хариуцна.

[Зааглах цэг хүртэл түрээсийн шугам ашиглаж байгаа бол тус шугам, сүлжээний ашиглалт үйлчилгээ, найдвартай ажиллагаа түүнтэй холбоотой бусад асуудлыг тусдаа гэрээгээр зохицуулах, ЭСВЭЛ телевизийн студээс Зааглах цэг хүртэлх сүлжээг Дамжуулагч тал хариуцах бол ашиглалт үйлчилгээ түүнтэй холбоотой төлбөр тооцоо зэргийг ойлгомжтой, тодорхой зааж өгөх]

3.2. Талууд өөрийн сүлжээнд энэхүү гэрээгээр зохицуулж байгаа холболтод хамаарах аливаа туршилт, техникийн шинэчлэл, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд ажиллах хугацаа, горимыг хуанлийн __7__ хоногийн өмнө урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.

3.3. Аль нэг Тал нь нөгөө Талынхаа үйлчилгээг тасалдуулахгүй байх үүргийг хүлээх ба хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан Тал нь шуурхай арга хэмжээ авч, нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх ба нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Энэхүү гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар Талуудын техникийн ажилтнууд тодорхой тэмдэглэл хөтөлж, удирдлагаар баталгаажуулан хадгална.

3.4. Аль нэг Талын буруутай үйлдлээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах тохиолдолд буруутай этгээд нь нөгөө Тал болон хэрэглэгчийг хохироохгүй байх бүхий л арга хэмжээг /хохирлыг нөхөн төлүүлэх гэх мэт/ авна.

3.5. Техникийн гэмтэл, саатал, үзлэг үйлчилгээний үед Дамжуулагч нь Телевизийн сувгаар дараах мэдэгдэл бүхий текстийг дамжуулна.

- 3.5.1. Дамжуулагч талд техникийн гэмтэл, саатал гарсан бол “ДАМЖУУЛАГЧИЙН СҮЛЖЭЭНД ГЭМТЭЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ”;
- 3.5.2. Телевизийн талд гэмтэл, саатал гарсан бол “ТЕЛЕВИЗЭД ТЕХНИКИЙН ГЭМТЭЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ”;
- 3.5.3. Хуваарьт үзлэг, үйлчилгээ хийж байгаа бол “ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ХИЙЖ БАЙНА.” боломжтой бол хэвийн үргэлжлэх хугацааг дурдах;
- 3.5.4. ...

3.6. Талууд ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл зэргийг хавсралт 3-д заасан байна.

3.7. Нүүх шилжих үеийн зохицуулалт:

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1. Телевиз нь энэхүү гэрээний хавсралт 4-д заасан төлбөрийг гэрээ байгуулснаас хойш ажлын хоногийн дотор Дамжуулагчийн банкны дансанд шилжүүлнэ. [\[Төлбөр авахгүй бол шаардлагагүй.\]](#)

4.2. Хавсралт 4-д заасан төлбөрийн хувийг Хавсралт ____-д заасан бартерын зарчмаар барагдуулна. [\[Төлбөрийг бартераар барагдуулах тохиолдолд энэ заалтыг ашиглаж болно.\]](#)

4.3. Талууд энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хэтэрсэн хоног тутамд хавсралт 4-д заасан төлбөрийн дүнгийн 0.5 хувиар тооцож, нөгөө талдаа алданги төлнө.

4.4. Талууд гэрээнд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдолд хавсралт 4-д заасан төлбөрийн дүнгийн ____ % /эсвэл _____ төгрөг [\[төлбөр тооцдоггүй тохиолдолд\]](#)/ -тай тэнцэх хэмжээний торгуулийг тооцно.

4.5. Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь төлбөрийн тооцоог сар бүр нийлнэ. Холбогдох ажилтны мэдээллийг Хавсралт 3-д заасан. Ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй. [\[Төлбөр авахгүй бол шаардлагагүй.\]](#)

Тав. Харилцан мэдээлэл солилцох

5.1. Телевиз нь долоо хоног бүрийн Баасан гаригийн ____ цагаас өмнө _____@_____ и-мэйл хаягаас дамжуулагч талын _____@_____ и-мэйл хаяг руу телевизийн хөтөлбөрийг илгээнэ. Телевизийн хөтөлбөр нь Хавсралт 5-д заасан форматын дагуу, үг үсгийн алдаагүй байна.

5.2. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах бол 5.1-д заасан хаягаар дамжуулагчид ____ цагийн өмнө урьдчилан мэдэгдэж, өөрчлөлтийг оруулна.

5.3. Дамжуулагч талд мэдэгдэлгүй хөтөлбөрт оруулсан өөрчлөлт, хөтөлбөрийг зөрүүлснээс үүссэн аливаа гомдол, маргаантай асуудлыг дамжуулагч тал хариуцахгүй. [\[Хариуцлага хэсэгт орж болно.\]](#)

5.4. Энэхүү гэрээний хүрээнд талууд харилцан мэдээлэл солилцоход дараах зарчим, дарааллыг баримтална. Үүнд:

- 5.4.1. Энэхүү гэрээний 3.4-д зааснаас бусад тохиолдолд энэхүү гэрээтэй холбоотой харилцааг талууд албан бичгээр эсхүл и-мэйлээр баталгаажуулна.
- 5.4.2. Нэг тал нөгөөдөө бичгээр гаргасан хүсэлтэд нөгөө тал ажлын 5 хоногийн дотор бичгээр хариу өгнө.
- 5.4.3. Мэдээлэл солилцох холбогдох чиглэл бүрийн ажилтны мэдээллийг Хавсралт –3 д заана.
- 5.4.4. Аль нэг талын нууц гэж үзсэн мэдээллийн нууцыг нөгөө тал хадгалах үүрэгтэй ба мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахгүй.

Зургаа. Хариуцлага

6.1. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх эсхүл зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээ, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан тохиолдолд учруулсан хохирлоо нөхөн төлөх үүрэгтэй.

6.3. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх, эсхүл удаа дараа биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал үүргийн гүйцэтгэлийг хангах дор дурьдсан аргыг шат дараатайгаар хэрэглэнэ. Үүнд:

- 6.3.1. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар мэдэгдэл хүргүүлэх.
- 6.3.2. энэхүү гэрээний 4.4-т заасны дагуу алданги тооцох;
- 6.3.3. аль нэг тал нь төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн тохиолдолд 1.6.7 заалтыг хэрэгжүүлэн хязгаарлалт, салгалтыг хийх;

6.4. Энэхүү гэрээний 6.3-т заасан арга хэмжээг хүлээсэн нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх хууль зүйн үндэслэл болохгүй.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Энэ гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг Зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлнэ.

7.2. Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг маргалдагч Талууд аль болох хүлээж авна. Хэрэв Зохицуулах хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол Талууд шүүхэд хандах эрхтэй.

Найм. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдгийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гэрчилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.

8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

8.5. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

Ес. Бусад

9.1. Талууд харилцан хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй.

9.2. Энэхүү гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

9.3. Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, өмчлөл өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран энэхүү гэрээний 1.2-т заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.4. Энэхүү гэрээнд 20__ оны __ дугаар сарын __-ний өдөр _____ /Улаанбаатар хотноо/ гарын үсэг зурав.

Талуудын албан ёсны хаяг, бусад өгөгдлүүд:

_____ХХК

_____ХХК

Хаяг:

Хаяг:

Бүртгэлийн гэрчилгээ: _____

Бүртгэлийн гэрчилгээ: _____

Регистрийн дугаар: _____

Регистрийн дугаар: _____

Утас: _____

Утас: _____

Факс: _____

Факс: _____

Электрон хаяг: _____

Электрон хаяг: _____

И-мэйл хаяг: _____

И-мэйл хаяг: _____

Гэрээ байгуулсан:

Гарын үсэг

Гарын үсэг

Нэр _____

Нэр _____

албан тушаал _____

албан тушаал _____

_____, _____-ЫН
 холболт, дамжууллын 20....
 оны . . . тоот гэрээний
 хавсралт 1

ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Телевизийн студизэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт (PAL)	[SD форматаар дамжуулах бол SMPTE 259M-C (SD-SDI), ITU-R BT601 стандартыг хангасан байх.]
	[HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI), ITU-R BT709 стандартыг хангасан байх.]
Дууны оролт	[Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)]
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дэлгэцийн харьцаа	[4:3, 16:9]
SD нягтрал /пикселийн тоо/	[SD-SDI 625@50i гэх мэт]
HD нягтрал /пикселийн тоо/	[HD-SDI, 1080@50i, шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264) гэх мэт]
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	[Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу дууны гаралтын түвшин -18dBFS, эгшин зуурын утга нь ± 1 байна.]
Дууны кодлол	[Стерео, MPEG layer 1, 2, 3 , AAC, AES гэх мэт]

Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

[Телевизийн студийн гаралтын дамжуулах төхөөрөмжөөс ОСДҮЭ дээр байрлах хүлээн авах төхөөрөмж хүртэлх болон холболтод ашиглагдах төхөөрөмжүүдийн мэдээллийг оруулна. Зааглах цэгээр тусгаарлан төхөөрөмжийг хамаарах талуудын дор бичнэ.]

Холболтын техник, төхөөрөмжийн нэр, зориулалт	Телевиз талд	Дамжуулагч талд (ОСДҮЭ)
Хөрвүүлэх төхөөрөмж (Encoder) түүний төрөл, марк, сериал дугаар		
Дамжуулах (Tx) / Хүлээн авах (Rx) төхөөрөмж түүний төрөл марк, сериал дугаар	Tx	Rx
Холбох шугамын төрөл, үзүүлэлт: 1 core fiber optic гэх мэт.		
Холболтын интерфэйс: HD-SDI, SD-SDI 75 Ом BNC, GbE-MPEGoIP гэх мэт өөрсдийн технологиос хамааруулан сонгож бичнэ.		
Бусад....		

_____ -ын холболт,
дамжууллын 20.... оны . . .
тоот гэрээний хавсралт 2

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ, ЗУРАГЛАЛ

	<i>Хаяг</i>
Зааглах цэгийн байршил	
Тоног төхөөрөмж	

ХОЛБОЛТЫН ЗУРАГ

[Телевизийн дамжуулах төхөөрөмжөөс ОСДҮЭ-ийн хүлээн авах төхөөрөмж хүртэл ашиглагдаж байгаа бүх төхөөрөмж, хөрвүүлэх төхөөрөмж, тэдгээрийн холбогдсон байдлыг схем зургаар харуулж, зааглах цэгийг тэмдэглэх]

_____ -ын холболт,
 дамжууллын 20.... оны . . . тоот
 гэрээний хавсралт 3

ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН

Дамжуулагч тал

№	Чиглэл	Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
1	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:				
2	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:				
3	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:				
4	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:				

Телевизийн тал

№	Чиглэл	Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
1	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:				
2	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:				
3	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:				
4	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:				

_____ -ын холболт,
дамжууллын 20.... оны . . .
тоот гэрээний хавсралт 4

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

	Төлбөрийн задаргаа	Үндэслэл, тайлбар	Төлбөрийн хэмжээ
1			
2			
3			
4			